



**БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН  
БИЕИЙН ТАМИР, СПОРТ ХОРООНЫ  
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 04 сарын 03 өдөр

Дугаар A/21

Улаанбаатар хот

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд суугаа волейболын нээлттэй арга хэмжээ зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалт, "Биеийн тамир, спортын тухай" хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.3 дахь заалт, 24 дүгээр зүйлийн 24.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Баянзүрх дүүргийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд суугаа волейболын нээлттэй арга хэмжээ 2023 оны 04 дүгээр сарын 15-наас 16-ны өдрүүдэд 147-р сургууль дээр зохион байгуулсугай.

2.Арга хэмжээний зардалд 4,490,000 (Дөрвөн сая дөрвөн зуун ерэн мянган) төгрөгийг нийтийн биеийн тамирын зардлаас гаргахыг нягтлан бодогч (П.Бат-Оюун)-д зөвшөөрсүгэй.

3.Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Биеийн тамирын хэлтсийн дарга (Э.Уянга)-д даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Д.ОТГОНСҮРЭН



Баянзүрх дүүргийн Биеийн тамир, спортын хорооны даргын 2023 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн А/21 тушаалын хавсралт

ТӨСӨВ

2023 оны 04 дүгээр сарын 03

Улаанбаатар хот

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд суугаа волейболын нээлттэй арга хэмжээ

Д/Д	Арга хэмжээний нэр	Хаана болох	Өргөмжлөл	Мөнгөн шагнал	Шүүгчийн хөлс, мөнгө	Бусад зардал	Нийт дүн
1	Суугаа волейбол		1-р байр 18*20,000=360,000 2-р байр 18*20,000=360,000 3-р байр 18*20,000=360,000	1-р байр 18*50,000=900,000 2-р байр 18*40,000=720,000 3-р байр 18*30,000=540,000	Ерөнхий шүүгч 1*150,000=150,000 Шүүгч 6*100,000=600,000	Аннос, 200,000 Гарын авлага 300,000	4,490,000